

Баяндэлгэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газрын
2024 оны 09 дүгээр сарын мэдээ

2024.09.27

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар:

а/ Сумын ИТХ-ын чиглэлээр: Улс орон даяар зохион байгуулагдсан улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөрт зориулан сумын хийдэд буяны ном хуруулж, зул өргөж хилс хэрэгт хэлмэгдэгсдийн гэгээн дурсгалыг хүндэтгэх ажлыг зохион байгуулсан.

б/ Тамгын газрын төрийн удирдлагын ажлын чиглэлээр:

Тухайн сард дээд газраас 15 албан бичиг ирсний 5 нь хариутай, хугацаа хоцорсон албан бичиг байхгүй болно. Сумын засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 13-ний өдрийн А/121 тоот захирамжаар Намрын ногоон өдрүүд -Баяндэлгэр 2024 арга хэмжээний хүрээнд “Эрүүл хүнс”, “Алтан намар” Хөнгөн үйлдвэрлэл үзэсгэлэн худалдааг 2024 оны 09 дүгээр сарын 25-д зохион байгуулсан.

Ахмад 2024 зүүн бүсийн 7 төрөлт тэмцээнд сумын ахмадын баг тамирчдыг оролцоход шатахууны дэмжлэг үзүүллээ.

Хоёр: Төсөв санхүүгийн чиглэлээр: 2024 оны орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ Шилэн дансанд тухай бүр болон сар, улирлаар тавигдах мэдээллийг бүрэн тавьж илгээлээ. Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэг бүрэн орж хуваарилсан. Байгууллагуудын тогтмол зардлыг хуваарийн дагуу олгосон. Төсөвт байгууллагуудын цалин болон бусад гүйлгээг төлбөрийн хүсэлтийн дагуу цаг хугацаанд нь санхүүгийн программд шивж гүйцэтгэн төлбөрийн хүсэлт болон баримтыг хуулгатай тулган архивын нэгж үүсгэн ажиллаа.

Статистикийн мал эмнэлгийн мэдээ, зоогийн газрын мэдээ, үнийн мэдээ, аж үйлдвэрийн мэдээ,хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн судалгаа, амьдрах орчин аюулгүй байдлын судалгааг хийсэн. Сар бүр орон нутгийн ерөнхий орлогыг тухай бүрд холбогдох дан руу хааж бичилтийг хийж гүйцэтгэж байна.

Төрийн сангийн цахим гүйлгээний систем санхүүгийн гүйлгээг тухай бүрд шивж цахимаар илгээж байна.

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд: "Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил-2024", "Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх 1 сарын аян"-ны хүрээнд Эрүүл мэндийн төв-өөс өдөрлөг зохион байгуулсан. Нийт өдөрлөгийн хүрээнд 99 иргэд хамрагдсан байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Боловсрол: 2024-2025 оны хичээлийн жилд хэрэгжих ESEL сургалтын намрын ангийн нээлт сургууль дээр зохион байгуулагдлаа. “Сургуулийн менежмент сайжруулах арга зүйд суралцах нь” сургалтад хамрагдсан сургуулийн захирал, сургалтын менежерүүд багш нарт түгээн дэлгэрүүлэлт хийж, сургуулийн менежментийн 2024-2025 оны “Зураглал”-аа сайжруулж, төлөвлөв.

“Үндэсний бичиг үсэг, номын өдөр-2024” хүрээнд зохион байгуулсан “Эх хэлээ эрхэмлэн дээдэлье” бүтээлийн уралдаанд идэвхтэй оролцсон анги хамт олны бүтээл, мөн сурагчдын ном зохиолын тэмдэглэл, бүтээлч ажлуудаар үзэсгэлэн гаргалаа. Нэгдүгээр ангийн “Бэлтгэл” бүлгийн хөтөлбөртөө амжилттай судалсан тайлангаа эцэг эх, үеийн найзууддаа тайлагналаа.

Эрүүл мэндийн төв: Нийт үзлэг-540, Урьдчилан сэргийлэх үзлэг-370, Алсын дуудлага-17, Гэрийн дуудлага-14, Идэвхитэй хяналт-24, Рентген зураг авалт-30, өдрийн эмчилгээнд-26, сэргээн засах эмчилгээ-26 иргэн хамрагдаж тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

“Эмийн зохистой хэрэглээг хамтдаа төлөвшүүлье” уриан дор эмийн зохистой хэрэглээ сэдвээр нийт 14 эмч эмнэлгийн ажилчдад сургалт зохион байгуулсан. Эрүүл мэндийн цахим хуудсаар дамжуулан зурагт хуудас, мэдээлэл бэлтгэж байршуулсан. Эмийн зохистой хэрэглээ сэдвээр гарын авлага бэлтгэж, тараасан.

Нийгмийн эрүүл мэндийн нэн тулгамдсан асуудал болоод буй гепатитын вирусийн халдварыг бууруулах, устгах зорилгоор дэлхий нийтээрээ жил бүрийн 07 сарын 28-ний өдрийг "Гепатиттай тэмцэх дэлхийн өдөр" болгон тодорхой уриан дор тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалын дагуу "Арга хэмжээ авах цаг нь болсон" уриан дор тэмдэглэн өнгөрүүлсэн

Долоо хоног бүрийн 4 дахь өдөр дотоодын сургалтын хийж хэвшүүлсэн. 3-р улиралд 10 удаа дотоодын сургалт хийсэн байна. Орон нутгийн хөгжлийн сангийн 19,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шүдний тоног төхөөрөмж худалдан авсан.

Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Хөдөө аж ахуй: Намрын ногоон өдрүүд- Сүхбаатарт үйлдвэрлэв 2024 арга хэмжээнд 9 өрхийн үйлдвэрлэгчид цагаан идээ, хүнсний ногоо, даршилсан ногоо, оёдол, гар урлал, арьсан эдлэл, шилмэл мал төрлөөр амжилттай оролцож, “ Импортыг орлох бүтээгдэхүүн” төрөлд тэргүүн байр, Баяндэлгэрийн улаан ямаа төрөлд хээлтэгч тусгай байр эзэлсэн.

Намрын ногоон өдрүүд-Баяндэлгэрт үйлдвэрлэв 2024 үзэсгэлэн худалдаанд 32 өрхийн үйлдвэрлэгчид цагаан идээ, хүнс, хүнсний ногоо, оёдол, арьсан эдлэл, дээсэн эдлэл, гар урлал, төмөр эдлэл төрлөөр оролцож, төрөл тус бүрээр шилдэг бүтээгдэхүүнийг шалгаруулж өрхийн орлогыг дэмжиж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлан ажилласан.

Өрхийн тариаланчдын ургац хураалтын нэгтгэлийг ХАА-8 маягтаар гаргаж статистикийн хэлтэст хүргүүллээ. Тухайн онд төмс 1,7 га талбайгаас 15,98 тн, хүнсний ногоо 1,15 га талбайгаас 9,509 тн ургац хураан авлаа.

Байгаль орчин: БОУАӨ яамнаас гаргасан зөвшөөрөлтэй аймгийн засаг даргын гэрээний дагуу тус суманд 4 шонхорын акт бичигдсэн.

